



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, <http://www.ndaatgal.mn>

2025.02.20

№

03/391

танай _____-ны № _____-т

АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА НАРТ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВД

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 02 дугаар сарын 19-ний өдрийн “2025 оныг Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бууруулах жил болгон зарлах тухай” А/38 дугаар тушаалыг хүргүүлж байна.

Тушаалын хэрэгжилтийг хангах ажлын нэгдсэн төлөвлөгөөг батлан хүргүүлэх бөгөөд өөрийн орон нутаг, дүүргийн онцлогт нийцүүлэн дэд төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, шимтгэлийн өрийг барагдуулах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулан ажиллана уу.

Хавсралт 1 хуудастай.

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

Б.ДАВААХҮҮ



525080542



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 02 дугаар сарын 19

Дугаар 17/38

Улаанбаатар хот

2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын
шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон
зарлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарласугай.

2.“Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарласантай холбогдуулан 2025 онд зохион байгуулах үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулан 2025 оны 2 дугаар сард багтаан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлын явцыг улирал бүр тайлагнаж ажиллахыг Шимтгэл хураалтын удирдлага, арга зүйн газар (Б.Батсүх), үйл ажиллагааны үр дүнг олон нийтэд мэдээлэн сурталчлахыг Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар (Д.Цэцэгбадам)-т, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод бүтцийн нэгжийн дарга нарт, орон нутгийн онцлогт нийцүүлэн төлөвлөгөө батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.“Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хяналт-үнэлгээ хийж, үр дүнг танилцуулахыг Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т даалгасугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Даваахүү)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА



Ц.ГАНЦЭЦЭГ

1525010132